



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/69

Чингис хот


Халаалт тооцох эзлэхүүнд хэмжилт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц сангийн зарцуулалт, зориулалтын нийтлэг журам", Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолоор баталсан "Аж ахуйн харилцааны дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн өмчит байгууллагуудын халаалт тооцох эзлэхүүнийг барилга, объект тус бүр дээр биет хэмжилт хийж тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хяналтын хэмжилт хийх хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажлын хэсгийн гишүүдийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

• 231010205